



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/АЗ

Улаанбаатар хот

Цахим ур чадварын кабинет, лаборатори байгуулах,
ашиглах журам батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32¹ дүгээр зүйлийн 32¹.1.3, 32¹.1.4, 32¹.1.8 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дахь зорилт, 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.2.1, 2.2.4.2 зорилт, Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ”, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим Үндэстэн” баримтлах чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цахим ур чадварын кабинет, лаборатори байгуулах, ашиглах журмыг нэгдүгээр, кабинетын үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний хуудсыг хоёрдугаар, лабораторийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Цахим ур чадварын кабинет, лаборатори байгуулах, ашиглах журмыг холбогдох нэгж, албан хаагчдад танилцуулж, дагаж мөрдүүлэхийг (Үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газар), хэвийн үйл ажиллагаа, хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэн ажиллахыг (Систем нэгтгэл, сургалт хөгжлийн газар), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг (Чанар хяналтын газар)-ын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Д.Жавхлан)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТБААТАР

1425010322

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
даргын 2025 оны 14 дүгээр сарын 18 ны өдрийн
1/23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЦАХИМ УР ЧАДВАРЫН КАБИНЕТ, ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын агуулга, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ялгаатай байдлыг бууруулах, бие даан бүтээлчээр хөгжих, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, туршилт, судалгаа хийх дэвшилтэд технологи, инновацад тулгуурласан тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн бүхий ил тод, нээлттэй, хамтын оролцоог хангасан, уян хатан, тэгш, хүртээмжтэй цахим ур чадварын кабинет, лаборатори (цаашид "кабинет, лаборатори" гэх)-ийг байгуулах, ашиглах, хамгаалах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. "Цахим ур чадварын кабинет" гэж бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх зориулалт бүхий техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж, гарын авлагаар хангагдсан өрөө, тасалгаа, танхим;

2.2. "Цахим ур чадварын лаборатори" гэж тусгай платформ, аппликейшн, цахим хэрэглэгдэхүүн (VR, AR гэх мэт), виртуал, дрон, робот, симуляц орчин бүрдүүлсэн дууны, дүрсний, дуу дүрсний, туршилт, судалгаа хийх, суралцах боломж бүхий дэвшилтэд технологи, тоног төхөөрөмжтэй орчныг.

Гурав. Цахим ур чадварын кабинет, лаборатори байгуулах үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Аймаг, нийслэлийн төрийн цахим үйлчилгээний асуудал хариуцсан нэгж нь нутгийн болон төрийн захиргааны, бусад байгууллагад цахим ур чадварын кабинет, лаборатори байгуулах талаар дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг хүргүүлж болно.

3.2. Цахим ур чадварын кабинет, лабораторийн тоо, нэршлийг хүчин чадал, хүний болон санхүүгийн нөөцөд үндэслэн тогтооно.

3.3. Цахим ур чадварын кабинет, лабораторийн сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, сургалтын материал, гарын авлага зэргийг боловсруулах асуудлыг тухайн нэгж хариуцаж, нутгийн болон төрийн захиргааны байгууллага нь ашиглалт, ажиллах орчин, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж болно.

3.4. Олон улсын байгууллага болон бусад хуулийн этгээд нь энэ журмын 3.4-т заасан үйл ажиллагаанд хандив¹, тусламж, дэмжлэг үзүүлж болно.

Дөрөв. Цахим ур чадварын кабинет, лабораторид тавигдах шаардлага

4.1. Энэ журмын 2.1, 2.2-т заасан кабинет, лаборатори нь бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын агуулга, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ялгаатай

¹ Тайлбар: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт "хандив"-д заасан нэр томьёоны тодорхойлолт, мөн хуулийн 17 зүйлд заасан зохицуулалтыг баримтална.

байдлыг бууруулах, бие даан бүтээлчээр хөгжих, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, туршилт, судалгаа хийх орчин байна.

4.2.“Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6799:2019”, “Хүний нөөцийн менежмент. Сургалт ба хөгжил MNS ISO 30422:2024” стандартад тус тус заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

4.3.Кабинет, лабораторийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод дүрэм, журам, ажиллах цагийн хуваарь, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай байж болно.

4.4.Дотоод дүрэм, журам, ажиллах цагийн хуваарь, аюулгүй ажиллагааны зааварчилгааг аймаг дахь төрийн цахим үйлчилгээний асуудал хариуцсан нэгж батална.

4.5.Цахим ур чадварын кабинет, лаборатори нь сургалтын агуулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгсэл, үзүүлэн, сурах бичиг, гарын авлага, арга зүйн материал бусад хэрэглэгдэхүүнээс бүрдсэн байх бөгөөд тэдгээр нь суралцагчийн онцлогт тохирсон, тэгш, хүртээмжтэй байна.

4.6.Техникийн болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус цэвэршүүлэгч, цахилгаан хангамж, агааржуулагч, туршилтад зориулсан ширээ, сандал, тодорхой чиглэлээр туршилт, судалгаа, дадлага ажил хийх тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгаалал болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэл, бусад шаардлагатай зүйлээр тоноглогдсон байна.

4.7.Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг цахим, танхим, хосолсон хэлбэрээр зохион байгуулах, орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангасан байх бөгөөд сургалтын таблет, зөөврийн, суурин компьютер, платформ, аппликейшн, цахим хэрэглэгдэхүүн (VR, Pico 4VR, AR гэх мэт), виртуал, дрон, робот, симуляц орчныг бүрдүүлсэн дууны, дүрсний, дуу дүрсний туршилт, судалгаа хийх, суралцах боломж бүхий дэвшилтэд технологи, олон үйлдэлт самбар, дотоод сүлжээ, утастай, утасгүй интернэт, дамжуулагч, веб болон хяналтын камер, микрофон, дууны өсгөгч, чанга яригч зэрэг тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

Тав. Цахим ур чадварын кабинет, лабораторийн ашиглалт, хяналт

5.1.Цахим ур чадварын кабинет, лабораторийн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сургалт зохион байгуулж байгаа төрийн цахим үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн ахлах ажилтан болон холбогдох байгууллагын томилогдсон албан хаагч ашиглалт баяжуулалт, засвар үйлчилгээ зэрэгт хяналт тавьж бүртгэл тэмдэглэгээг хөтөлнө.

5.2.Цахим ур чадварын кабинет, лабораторийн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг зөөвөрлөн ашиглах үйл ажиллагааг аймаг дахь төрийн цахим үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн даргын зөвшөөрлөөр үйлчилгээний ахлах ажилтан болон холбогдох байгууллагын томилогдсон албан хаагч хариуцна.

5.3.Цахим ур чадварын кабинет, лабораторийн сүлжээ, холболтын найдвартай, бэлэн байдлыг аймаг дахь төрийн цахим үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн ахлах ажилтан болон холбогдох байгууллагын томилогдсон албан хаагч хариуцна.

5.4.Үйл ажиллагааны тайланг аймаг дахь төрийн цахим үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн ахлах ажилтан болон холбогдох байгууллагын томилогдсон албан хаагч сар, улирал, хагас, бүтэн жилээр нутгийн эсхүл төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

5.5.Үйл ажиллагаа явуулж байгаа цахим ур чадварын кабинет, лабораторийн үйл ажиллагаанд жил бүрийн 4 дүгээр сард багтаан төлөвлөгөөт, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус үнэлгээ хийж, 80 хувиас дээш буюу “хангалттай” үнэлэгдвэл үргэлжлүүлэх, “хангалтгүй” үнэлэгдвэл шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллана.

5.6.Мэргэжлийн ур чадвартай ажилтныг бэлтгэх хүрээнд кабинет, лабораторид харилцаа холбоо, мэдээлэл технологийн мэргэжилтэн, албан хаагчдыг сургаж, дадлагажуулж болно.

Зургаа. Хариуцлага

6.1.Энэхүү журмыг зөрчсөн албан хаагчид холбогдох хууль тогтоомж болон тус газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Долоо. Бусад

7.1.Сургалтад хамрагдсан хүний сэтгэл ханамж, ур чадвар, түвшин тогтоох үйл ажиллагааг үе шаттайгаар тогтмол зохион байгуулж, сайжруулах арга хэмжээг тухай бүр авч ажиллана.

7.2.Цахим ур чадварын кабинет, лабораторид хүний эрхийг илтэд зөрчсөн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.3.Цахим ур чадварын кабинет, лабораторийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахыг хориглоно.

7.4.Журмаар нарийвчлан зохицуулагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу зохицуулна.

--oOo--

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
даргын 2024 оны 01 дүгээр сарын 16 -ний өдрийн
А/БЗ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ЦАХИМ УР ЧАДВАРЫН КАБИНЕТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХУУДАС**

№	Тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн	Шаардлага хангасан эсэх /0-100 оноо/	Тайлбар
Нэг. Ашиглалт			
1.	гэрэлтүүлэг		
2.	агааржуулалт		
3.	эрүүл ахуйн шаардлага (мөөгөнцөр, халаалт, хөргүүр)		
4.	цэвэрлэгээ, тохижилт эмх цэгц		
5.	эд хөрөнгийн аюулгүй байдал /хаалга, цонх, цоож, лац гэх мэт/		
6.	сандал		
7.	ширээ		
8.	хогийн сав		
9.	хогийн шүүр		
10.	цэвэрлэгээний материал		
11.	"MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага"-ын холбогдох үзүүлэлт		
12.	"MNS ISO 30422:2024 Хүний нөөцийн менежмент. Сургалт ба хөгжил"-ын холбогдох үзүүлэлт		
13.	галын хор, анхан шатны тусламжийн хайрцаг		
14.	эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгаа		
15.	багаж хэрэгсэл, үзүүлэн, сурах бичиг, гарын авлага, арга зүйн материал		
16.	техникийн болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус цэвэршүүлэгч		
17.	цахилгаан хангамж		
18.	хөдөлмөр хамгаалал болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэл		
Хоёр. Техник, тоног төхөөрөмж, программ хангамж			
19.	компьютер /ширээний, зөөврийн/		
20.	дэлгэц		
21.	нэмэлт дэлгэц		
22.	гар		
23.	хулгана		
24.	дэлгэц (LED)		
25.	интернэт		
26.	микрофон, чихэвч, хяналтын камер бусад нэмэлт тоног төхөөрөмж		
27.	сургалтын хэрэглэгдэхүүн /гарын авлага, контент, тараах материал гэх мэт/		

28.	программ хангамж/албан ёсны эрхтэй эсэх/		
29.	Хяналтын камер		
Нийт			

БАТАЛГААЖУУЛАЛТ

Хяналт хийсэн албан тушаалтны нэр:
/овог, нэр/

/гарын үсэг/

Хүлээн зөвшөөрсөн ажилтны нэр:
/овог, нэр/

/гарын үсэг/

--oOo--

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн
А/Б дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ЦАХИМ УР ЧАДВАРЫН ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

№	Тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн	Шаардлага хангасан эсэх /0-100 оноо/	Тайлбар
Нэг. Ашиглалт			
1.	гэрэлтүүлэг		
2.	агааржуулалт		
3.	эрүүл ахуйн шаардлага (мөөгөнцөр, халаалт, хөргүүр)		
4.	цэвэрлэгээ, тохижилт эмх цэгц		
5.	эд хөрөнгийн аюулгүй байдал /хаалга, цонх, цоож, лац гэх мэт/		
6.	сандал		
7.	ширээ		
8.	хогийн сав		
9.	хогийн шүүр		
10.	цэвэрлэгээний материал		
11.	"MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага"-ын холбогдох үзүүлэлт		
12.	"MNS ISO 30422:2024 Хүний нөөцийн менежмент. Сургалт ба хөгжил"-ын холбогдох үзүүлэлт		
13.	галын хор, анхан шатны тусламжийн хайрцаг		
14.	эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгаа		
15.	багаж хэрэгсэл, үзүүлэн, сурах бичиг, гарын авлага, арга зүйн материал		
16.	техникийн болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус цэвэршүүлэгч		
17.	цахилгаан хангамж		
18.	хөдөлмөр хамгаалал болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэл		
19.	тодорхой чиглэлээр туршилт, судалгаа, дадлага ажил хийх тоног төхөөрөмж		
20.	хөдөлмөр хамгаалал болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэл		
Хоёр. Техник, тоног төхөөрөмж			
21.	компьютер /ширээний, зөөврийн/		
22.	дэлгэц		
23.	нэмэлт дэлгэц		
24.	гар		
25.	хулгана		
26.	дэлгэц (LED)		

27.	интернэт		
28.	микрофон, динамик, чихэвч, болон бусад аудио тоног төхөөрөмж		
29.	виртуал бодит байдал (VR, AR, Pico 4VR) төхөөрөмжүүд		
30.	Робот, дрон гэх мэт дэвшилтэд технологи		
31.	микрофон, чихэвч, хяналтын камер бусад нэмэлт тоног төхөөрөмж		
32.	сургалтын хэрэглэгдэхүүн /гарын авлага, контент, тараах материал гэх мэт/		
33.	программ хангамж/албан ёсны эрхтэй эсэх/		
34.	Хяналтын камер		
Нийт			

БАТАЛГААЖУУЛАЛТ

Хяналт хийсэн албан тушаалтны нэр:
/овог, нэр/

/гарын үсэг/

Хүлээн зөвшөөрсөн ажилтны нэр:
/овог, нэр/

/гарын үсэг/

--oOo--